

Батлав:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын дарга:

/ А. ЭНХБАТ/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Цээцээ импекс” ХХК-ийн захирал:*Лавсан*...../Э.ГАНТУЯА/



**УЛААНБААТАР ХОТЫН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НУТАГ
ДЭВСГЭРТ ОРШИХ “ИХБУЛАГ”-ИЙН БАРИЛГЫН ЧУЛУУНЫ
ОРДЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Тусгай зөвшөөрлийн дугаар MV-007134/

/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар 2804816/

Хянасан:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ Ц. ЖАРГАЛНЭМЭХ/

Төв аймгийн БОАЖГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ С.ЭРДЭНЭЦОГТ /

Боловсруулсан:

“ЦЭЭЦЭЭ ИМПЕКС” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн:

З. Болорцэцэг

/З. БОЛОРЦЭЦЭГ/

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

ГАРЧИГ

ОРШИЛ	3
НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
1.1.Төлөвлөгөөний нэр	4
1.2.Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	4
1.3.Төслийн зорилго.....	4
1.4.Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	4
1.5. Төслийн байршил.....	4
1.6. Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	5
1.7. Төслийн үйлдвэрлэлийн нөөц.....	5
1.8. Ил уурхайн ашиглалтын технологи	6
1.9. Уулын ажлын горим	6
1.10. Төслийн хүчин чадал	7
1.11.Тоног төхөөрөмжүүд	7
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
2.1.Байгаль орчны төлөв байдал.....	8
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
3.1.Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	10
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	12
4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт	12
4.2. БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл.....	13
4.3. БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга	13
4.4. БОМТ-ний бүтэц.....	15
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	18
5.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ...	18
5.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	19
5.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
5.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
5.7.Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
5.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
5.9.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	23
5.10. Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	24
5.11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	25
5.12.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	26
ДҮГНЭЛТ	26
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1. Үзүүлэлт /”Цээцээ Импекс” ХХК/.....	4
Хүснэгт № 2. Уурхайн солбилцол.....	5
Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт № 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт № 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт № 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт № 7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт № 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт № 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
Хүснэгт № 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
Хүснэгт № 11. БОМТ-ийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	25
Хүснэгт № 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	26

ОРШИЛ

“Цээцээ импекс” ХХК –ийн барилгын чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 7.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

НЭГ.ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1.Төлөвлөгөөний нэр

“Их булаг”–ийн барилгын чулууны ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1.2.Төсөл хэрэгжүүлэгч байгууллага

“Цээцээ импекс” ХХК

1.3.Төслийн зорилго

“Их булаг” ордын барилгын чулууг олборлож, бутлан ангилан, сайн чанарын дайрга зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

1.4.Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт № 1. Үзүүлэлт /“Цээцээ Импекс” ХХК/

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Цээцээ Импекс” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011137041	
3	Уурхайн нэр	“Их булаг”	
4	Ордын нэр	“Их булаг”	
5	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар
6		Сум/Дүүрэг	Баянзүрх
7	Ашигт малтмалын төрөл	Барилгын чулуу	
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-007134	
9	Ашиглалт эхэлсэн огноо	-	
10	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
11		Сум/Дүүрэг	Чингэлтэй
12		Баг/Хороо	19-р хороо
13		Гудамж/Байр	Шадивлан 1-90 404 тоот
14		Утас	976-11-461757
15		Факс	976-11-461757
16		Гар утас	91915431
17	Электрон шуудан	Tseestee_impex@yahoo.com	
18	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Э.Гантуяа
19		Гар утас	91915431


1.5.Төслийн байршил

“Их булаг” барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20-р хорооны Гачуурт тосгоны нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс зүүн урагш 20 км зайд оршино (1-р зураг).

Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэмшиж буй талбайн захын цэгүүдийн солбицол:

Хүснэгт № 2. Уурхайн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1.	107° 06' 41,39"	47° 55' 26,78"
2.	107° 06' 11,39"	47° 55' 26,78"
3.	107° 06' 11,39"	47° 56' 31,79"
4.	107° 06' 41,39"	47° 56' 31,79"



Зураг 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг

1.6. Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших “Их булаг” нэртэй 125 га талбай бүхий ашигт малтмалын MV-007134 дугаартай тусгай зөвшөөрлийг 2008 оны 03 дугээр сарын 24-ны өдөр “Цээцээ Импекс” ХХК-д шилжүүлсэн байна.

1.7. Төслийн үйлдвэрлэлийн нөөц

Их булагийн барилгын чулууны ордын 2019 оны эхэн дэх үлдэгдэл нөөцөд тулгуурлан ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд уурхайн хил хязгаар дотор орших хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 9-р сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу бодитой (В) зэргийн нөөц, олборлолтонд өртөж байгаа боломжтой (С) зэргийн нөөцийг магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан

В' зэргээр 298.47 мян.м³ буюу 722.51 мян.тн барилгын чулуу байна. 2023 онд нийт 298.47 мян.м³ дайрга олборлон үйлдвэрлэн борлуулна.

1.8. Ил уурхайн ашиглалтын технологи

Уул-техникийн нөхцөл: Тухайн ордын уул геологийн нөхцөлд тохирох технологийг сонгон хэрэгжүүлж, зохион байгуулалтын хувьд бэрхшээлгүй үйлдвэрлэл явуулан, эдийн засгийн үр өгөөжийг хангахад ашигт малтмалын ордыг ашиглах аргын үндсэн зорилго чиглэдэг. Их булагийн барилгын чулууны ордын бодитой В зэрэглэлээр бодогдсон геологийн нөөцийн үлдэгдэл 14.24 сая.м³ байна.

Уг ордын олборлолтын ажлыг ил уурхайн аргаар олборлолт явуулж байгаа ба В зэрэглэлийн нөөцийг ашиглах уул-техникийн нөхцөл болон бусад хүчин зүйлээс харгалзан үзэхэд ил аргаар ашиглахад эдийн засгийн хувьд үр ашигтай байна.

Ордын барилгын чулууны биетийн тогтоц, хөрсний зузаан, газар зүйн байрлал, хөрсний чулуулгийн шинж чанар зэрэг гол үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр уг ил уурхайг тээвэртэй ашиглалтын системийг сонгож ажиллаж байна.

Ашиглалтын систем: Ордыг ил аргаар, авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглана.

Уурхайн нээлт: Ордын уул-техникийн нөхцөл нь уул толгодын ар налуу газар байх бөгөөд тус уурхай нь уурхайг өндрөөс нам тал руу нь хөрс хуулалт хамгийн бага, цаашид хөрс хуулалтыг жигд тогтвортой байхаар өмнөх жилүүдийн олборлолтыг үргэлжлүүлж оновчилж хийсэн.

1.9. Уулын ажлын горим

Уурхайн олборлолт хөрс хуулалтын үйл ажиллагаа нь жил бүрийн 4-р сараас 10-р сарыг дуустал дулааны улиралд явагдах бөгөөд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын саатал, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлийг тооцсон. Уурхай нь энгийн ажлын цагаар ажиллуулж Улаанбаатар хот – Уурхай гэсэн чиглэлд ээлжийн эхлэл төгсгөлд зориулалтын автобусаар үйлчилж тээвэрлэнэ.

2023 онд 4 сарын 15-наас 11 сарын 1-нийг дуустал 193 хоногоор, хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана.

1.10. Төслийн хүчин чадал

Их булаг уурхайн хүчин чадлыг захиалагч компаниас өгсөн техникийн даалгавар, борлуулалтын гэрээ, ашиглах техникүүдийн хүчин чадал одоогийн байдалд тулгуурлан тооцсон. Ил уурхайн жил бүрийн олборлолт харилцан адилгүй байх ба жилд хамгийн ихдээ 300.0 мян.м³ (сийрэгжээгүйгээр) барилгын чулуу олборлохоор тооцлоо. Ил уурхайн барилгын чулуу олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход 57 жилийн хугацаанд олборлохоор байна.

“Их булаг” барилгын чулууны уурхайгаас 2023 онд 298,4 мян.м³ барилгын чулуу олборлон борлуулна.

1.11. Тоног төхөөрөмжүүд

Уулын ажилд хэрэглэгдэх үндсэн тоног төхөөрөмжүүдийг “Цээцээ импекс” ХХК худалдан авсан буюу одоо уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүд юм. Тэдгээрийн бүтээлийг тооцоолон жил бүрийн уулын ажлын хэмжээтэй уялдуулан ТЭЗҮ-д тусгахыг захиалагч байгууллага төслийн техникийн даалгавараар даалгасны дагуу бүтээлийг тооцон, уулын ажлын хэмжээтэй уялдуулан шаардлагатай тоног төхөөрөмжийг тооцсон.

Техникийн даалгаварт тусгагдсан уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд Everdigm-ECD45 маркийн өрмийн машин-1ш (өрөмдлөг тэсэлгээний оператор компани болох “Повер бласт” ХХК-ийн тус ордод ашиглаж байгаа машин), CAT 330 DL маркийн экскаватор 1 ширхэг, CAT 329 DL маркийн экскаватор 1 ширхэг, CAT 320 DL маркийн экскаватор 1 ширхэг, DOOSAN DX225 LCA маркийн экскаватор 1 ширхэг, 25 тн даацтай HowoZZ3257 автосамосвал 6 ширхэг, Howo ZZ3257 автосамосвал 1 ширхэг, Luigong CLG 855H утгуурт ачигч 2 ширхэг байна.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчны төлөв байдал

Физик газарзүй: “Их булаг” барилгын чулууны орд нь засаг захиргааны хуваариар Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Гачуурт тосгоны нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс зүүн урагш 20 км-т оршино.

Уул зүй: Ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун хэсэгт хамаарагдах ба далайн түвшнээс дээш 1370-1435 м байна.

Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэл хэрчигдэлд нилээд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй. Орд байрлаж буй хөндий нь хойноосоо урагш чиглэсэн налуувтар нарийхан гонзгойдуу хэлбэртэй, түүний баруун зүүн талаар намхан уул толгодлог рельефээр хүрээлэгдсэн байна.

Усан сүлжээ: Ордын ойр орчимд гадаргуугийн урсгал ус гол горхи байхгүй. Хамгийн ойролцоо буюу ордоос зүүн тийш 3км-т Гачуурт гол /Туул голд цутгадаг/, ордоос урагш 2.1км-т Туул гол урсан өнгөрөх ба Туул голын усны түвшин маш тогтворгүй, зун борооны үед голын усны түвшингийн хоногийн хэлбэлзэл 50-60см-ээр дээшилдэг. Туул голын усны урсгалын хурд 1.2 м/сек, голын усны өргөн 30-70м, гүн нь 0.8-3.5м байна. Хөндийн гуу жалгаар хур борооны усаар дүүргэгдэж түр зуурын урсац бий болдог.

Судалгааны талбайн хэмжээнд хэрэглээний усны хэрэгцээг 2016 онд өрөмдөж гаргасан гүний худгаас хангадаг. Лицензийн талбайд хайгуулын ажлын явцад 40м хүртэл өрөмдөхөд уст давхарга илрээгүй.

Хөрс: Мужлалаар хангай хээрийн бүсэд хамаарагдана. Уулархаг хэсгээрээ хар шороон түүнээс доошлоход уулын нугын хар, хар хүрэн, хүрэн бор, хөндий хотгор газартаа бараан өнгийн хөрс зонхилсон бүслүүрлэг зүй тогтоцтой байна. Хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газарзүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй юм.

Ургамал: Ордын орчим нь тал хээрийн бүсэд ургадаг бутлаг ургамал болох залаат ургамал элбэг тохиолдох боловч хонхордуу газар харьцангуй бага тохиолдоно. Эдгээр нь бага эрдэсжилттэй, газар доорх усаар тэжээгддэг. Зуны улиралд ургамлын бүрхэвч харьцангуй шигүү бөгөөд өндөр ургасан байдаг ба Туул голын эргээр бургас харгана

мэтийн модлог ургамал дов толгодын хоорондох нуга, суваг, булаг шанд задгай устай газарт дэрс өндөр ургасан байдаг байна.

Ан амьтан: Тарвага, хярс, зурам, оготно, жигүүртнээс шаазгай, шар шувуу, хэрээ зэрэг ан амьтадтай.

Цаг агаар: Судалгааны талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хамгийн хүйтэн нь 1-р сард -38°C , дулаан нь 7-р сард $+33^{\circ}\text{C}$ хүрнэ.

Жилд унах тунадасны дундаж хэмжээ 230-350мм-ээс хэтрэхгүй, түүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр унах ба 15-30% нь өвөл, хаврын улиралд цас хэлбэрээр унадаг. Салхины хурд өвөлдөө 5-9м/сек, зун 3-4м/сек, хавартаа хааяа 10-15 м/сек хүртэл салхилдаг.

Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг. Цэвдэгшилийн мужлалаар алаг цоог тархалттай бүс нутагт хамаарах боловч лицензийн талбайд цэвдэгшил ажиглагдаагүй. Өвөлдөө хөрсний хөлдөлтийн гүн дунджаар 2.0-3.0 м-т хүрдэг.

Хүн амын суурьшил, дэд бүтэц: Суурьшлын бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүх нутагт харьяалагдана.

Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдсон тул жилийн аль ч улиралд авто замын тээврээр уг ордын дүүрэгт зорчин очих боломжтой. Мөн өндөр хүчдэлийн шугам, үүрэн телефоны Mobicom, Skytel, Unitel, G-mobile зэрэг операторуудын сүлжээтэй.

Сүүлийн жилүүдийн геологийн судалгаагаар тус дүүрэгт үйлдвэрлэлийн ач холбогдолтой барилгын материалын түүхий эдийн ордууд нээгдэж байгаа.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт зэргээс ихээхэн хоосон орон зай үүсэх бөгөөд хөрсөн бүрхэвч, ургамал болон шавжнуудын амьдрах орчинг өөрчилж ховор болон эндемик/унаган/төрөл зүйлийг багасгах магадлалтай. Үйл ажиллагааны турш тээвэрлэлт явагдах тул талбайн ойр орчмын газрын гадаргыг тоос дарж хөрс, ургамал, орчныг бохирдуулна.

Хогийн цэгээс үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл: Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадаргад бохирдол үүснэ. Хэдийгээр дунд хугацаанд нөлөөлөл үзүүлэх боловч төслийн хугацаа дуусахад эргэн нөхөн сэргээгдэх боломжтой.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Замын хөдөлгөөн, тэсэлгээ хөрс хуулалт, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын тоосжилт, дизель түлшээр ажилладаг машин механизм тоног төхөөрөмж, тэсэлгээнээс үүссэн бохир хий утаа, дуу чимээ, хог хаягдлаас үүсэх үнэр зэрэг болно.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайн технологийн болон унд-ахуйн усны хэрэгцээг гүний худгаас авч ашиглах бөгөөд энэ нь газрын доорх усны хомсдолд үүсгэж болзошгүй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл: Ойролцоо орших олборлолтын талбай болон тэдгээр талбайруу шатах тослох материалын тээвэрлэлт, хүдрийн олборлолт зэргийн тээвэрлэлтээс шалтгаалсан техникийн олон салаа зам үүсч тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах хөрсний гадаргад хуурай тоос шороон хучаас үүсгэх.

Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулна. Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүснэ. Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулж болзошгүй.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Ил уурхайн талбайд байсан ургамал устана. Уурхайд олон янзын зориулалтаар машин техник ашиглаж, тэдгээрээс үүдэн олон салаа зам үүсч бий болох магадлалтай. Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадаргад шороо тоос үүсч, улмаар салхи шуурганд хийсэн ойр орчмын ургамал бүрхэвч, төслийн талбай тоос шороонд дарагдаж болзошгүй. Байгууламжууд баригдах талбай нь төслийн хугацаанд хүний хөлөөр болон тээврийн хэрэгслээр талхлагдаж бүрэн өөрчлөлтөнд орно. Тосгоноос ахуйн хог хаягдал их хэмжээгээр үүсч, хадгалах зайлуулах стандарт, дүрэм, журам барьж ажиллаагүйгээс гадаргад бохирдол үүсч болзошгүй. Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадарга болон ургамлан нөмрөгт бохирдол үүснэ. Тоосжилт үүссэнээс ойр орчмын ургамлууд дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Олборлолт явуулсны улмаас хөрс хуулж овоолго хийгээд орхисон байгаа ба овоолго болон түүний орчмын талбайн амьтан /элдэв шавжийн бүлгэмдэл/, тэдгээрийн амьдрах орчин үгүй болох.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Ажилчдын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна. Уурхайн ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, усны чанарт усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- ✓ Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- ✓ Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох,
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

“Цээцээ импекс” ХХК-ийн 2023 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

Зорилго: “Цээцээ импекс” ХХК-ийн барилгын чулууны ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго оршино.

4.2. БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл

Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор **Байгаль орчны менежмент** гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь **Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)** –ний дагуу **Байгаль орчны удирдлагын тогтолцоо(БОУТ)** –гоор хэрэгжих учиртай. **БОМТ** гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар **БОУТ** гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

4.3. БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан

байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зайлуулах арга хэмжээ
- ✓ Нөлөөллийг бууруулах арга хэмжээ
- ✓ Нөхөн сэргээлтийн арга хэмжээ /техникийн, биологийн/
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
- ✓ Тухайн жилийн БОМТ хэрэлжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ
- ✓ Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ
- ✓ Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

4.4.БОМТ-ний бүтэц

БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 8 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга
4. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Энэ хэсэгт Байгаль хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдийг тус бүрээр нь шийдэл болон тэдгээрийг хэрэгжүүлэхийн тулд авах арга хэмжээ, явуулах үйл ажиллагаа, хариуцах эзэн, хугацаа, төсөв зэргийг нэгтгэн хүснэгтийн хэлбэрт оруулан тайлбарласан.
7. Дүгнэлт
8. Ашигласан хэвлэл

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар							
1	Хөрс хуулалт, барилгын чулуу олборлолт, тээвэрлэлт, хөрсний овоолгоноос тоосжилт үүсэж орчны агаар орчныг бохирдуулах	Тоос үүсгэх талбайг тогтмол услах	Тээвэрлэлтийн зам	-	Үйл ажиллагааны зардлаар	Тухайн үед	-MNS 0017-2-3-16:1988. Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам. - MNS 3384-1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага. - MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS0017-2-5-11:1988. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2	Хүнд машин механизмын нөлөөгөөр Nox, CO, Sox хийгээр агаар орчныг бохирдуулах	Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Хүнд машин, техникүүд	-	600,000	2023 онд	
Гадаргын ба газрын доорх усны нөөц							
1	Газрын доорх усны нөөцөд нөлөөлөх	Усны төлбөрийг тогтсон хугацаанд жил болгон төлж байх	Гүний худаг	-	500,000	2023 онд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль / Ерөнхий сайдын захирамжийг мөрдлөг болгох / Ус ашигласны төлбөр (2009 оны 351-р тогтоол) MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч							

2	- Зам дагуу хөрс эвдэрч, тоос тархах	Зам арчилгааны зардал, эвдэрсэн тохиолдолд засах	Зам	-	Дотоод төлөвлөлтөөр	Эвдэрсэн үед	
4	Хөрс хуулалт, хөрсний овоолгоос газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдөх, эвдрэх	Ил уурхайн талбайн хэмжээнээс хэтэрч ажиллахгүй байх	Ил уурхай	-	Дотоод төлөвлөлтөөр	Байнга	
Ургамлан нөмрөг							
1	Ургамлын биомассд нөлөөлөх	Тоос үүсэх талбайг услах, олон салаа зам гаргахгүй гаргасан замаараа зорчих	Уурхайд	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ургамал хамгааллын тухай 1995 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн байгалийн ургамлын тухай хууль
Амьтны аймаг							
1	Төслийн талбай дах шавжийн бүлгэмдэл устгах, амьтад дайжих	Төслийн явцад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, шинээр бий болсон орчинд тухайн нутагт өмнө нь тохиолдож байгаагүй, эсвэл тоо толгой нь цөөн байсан амьтад шилжин суурьшиж болзошгүй тул уурхайн ашиглалтаас гарсан талбайд нэн даруй нөхөн сэргээх ажлыг зохион байгуулж байх шаардлагатай	Ойр орчмын амьтад, шувууд	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн амьтны тухай хууль

5.2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт № 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Техникийн нөхөн сэргээлт	ТНС хийгдэхгүй	-	-	-	-	-	MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт MNS 5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
2	Биологийн нөхөн сэргээлт	БНС хийгдэхгүй	-	-	-	-	-	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах.Техникийн шаардлага MNS 4919:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
Нийт								-

5.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт № 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Баримтлах стандарт, аргачлал
1	Унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах	Нийслэлийн байгаль орчны газраас санал болгосон дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажил хийнэ.	-	-	5,000.000	МУ-ын хууль дүрэм журмын дагуу
Нийт					5,000.000	

5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Их булаг” барилгын чулууны ордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

5.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Барилгын чулууны ордын эзэмшлийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд нэн даруй дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгуулагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.

5.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Хүснэгт № 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	300,000.0	Байнга	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS 6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги
2	шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	-	Үйл ажиллагааны зардлаар	Жилд 1 удаа	
3	үүсэх	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхай орчимд	-	350,000.0	Үйл ажиллагааны туршид	
Нийт зардал						650,000.0	

5.7.Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Цээцээ Импекс” ХХК-ийн “Их булаг” барилгын чулууны ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад энгийн найрлагат “ANFO”, “Аянга” тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан ашигладаг. Тэсрэх материал, тэсэлгээний хэрэгслийг Налайх дүүргийн нутагт орших агуулахаас зөөж тээвэрлэн мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг. Тэсэлгээний тусгай зөвшөөрөл бүхий гэрээт мэргэжлийн байгууллага нь тэсэлгээний ажлыг гүйцэтгэхдээ тусгайлан ХАБЭА-н менежментийн төлөвлөгөөг баримтлан ажилладаг.

Уурхайн талбайд байрлах 25 тонны ШТМ-ын 1 ёмкостын талбайг хайргаар хучин химийн бодис асгарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан.

“Их булаг” барилгын чулууны ордын тэсэлгээний ажлыг тэсэлгээний тусгай зөвшөөрөл бүхий “Пауэрбласт” ХХК-ийн мэргэжлийн инженерүүд гэрээгээр хариуцан гүйцэтгэдэг. Тэсэлгээний ажлын аюулгүй байдлыг гэрээт компани тусгай төлөвлөгөөний дагуу хариуцан ажилладаг.

Хүснэгт № 7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хариуцах эзэн	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
1	Тэсрэх бодис тэсрэх, асгарах, хэрэглэсэн тэсрэх бодисын сав баглаа боодлыг ил задгай хаях	Болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх	Барилгын чулууны уурхайд	“Пауэрбласт” ХХК	“Пауэрбласт” ХХК-тай байгуулсан гэрээний үнийн дүнд багтана.	2023 онд	-Галын аюулгүй байдлын тухай хууль -Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль -Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
2		Тэсрэх бодисыг хадгалах, ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад сав баглаа боодол задарч асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх	Барилгын чулууны уурхайд				

3		Тэсрэх бодис асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг бэлтгэж бэлэн болгох	Барилгын чулууны уурхайд				
4		Ашиглагдсан тэсрэх бодисын сав баглаа боодлыг орон нутгаас зааж өгсөн талбайд булшлах, устгах арга хэмжээ авах	Барилгын чулууны уурхайд				

5.8.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Цээцээ Импекс” ХХК нь Баянзүрх дүүргийн 20-р хорооны “Дэд бүтэц, тохижилтын хэлтэс”-тэй тохижилт, цэвэрлэгээний гэрээ байгуулан ажилладаг бөгөөд гэрээт байгууллага хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, компаний зүгээс хяналт тавьж ажилладаг.

Хүснэгт № 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөл-лийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэм-жээ	Нийт зардал, төг	Хэрэг-жүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлаас орчны бохирдол үүсэх	Хог тээвэрлэх компанитай байгуулсан гэрээний дагуу хогийг цаг хугацаанд нь тээвэрлүүлж байх	Хөрс, агаар, газрын доорх ус	-	-	250,000	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль
Нийт зардал						250,000		

5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт № 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаар						
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Бутлуур, дотоод тээвэрлэлтийн замаас, ил уурхай	Жилд 1 удаа	150,000	Цаг уур орчны шинжилгээний газрын байгаль орчны хэмжилзүйн төв лаборатори	- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль -MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 0017-2-3-16:1988. Агаар мандал. Хот суурингийн агаарын бохирдлын шинжилгээ - MNS 5061:2001. Нүүрсхүчлийн хий. CO ₂ тодорхойлох эзлэхүүний арга
2	Дуу чимээ, агаарын чийгшил, хөрсний температур хэмжих	Бутлуур, ил уурхай, уурхайн кемп	Жилд 1 удаа	Өөрсдийн багажаараа хэмжилтээ хийнэ	/Multi-Function environment meter багажаар хэмжих/	
Хөрс						
3	Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	Уурхайн карьерийн гадна талаас зонхилох салхины чиглэлийн дагуу	Жилд 2 удаа	40,000	ШУА, Газарзүй-Геозкологийн хүрээлэн, хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. -MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл -MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
4	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	Шатах тослох материалын агуулах, бохирдсон байж болох цэгүүдэс дээж авах	Жилд 1 удаа	45,000		
Ус						

5	Усны химийн шинжилгээ (рН, ЕС, TDS) нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Ахуйн хэрэглээний уснаас	Жилд 2 удаа	92,000	ШУА, Газарзүй-Геозкологийн хүрээлэн, усны шинжилгээний лаборатори	- MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга. - MNS5667-2:2001 Усны дээж. Дээж авах. 2-р хэсэг. Дээж авах аргачлалын заавар - MNS4867:1999Усны чанар – Дээжлэх – Хэсэг 3. Авсан дээжийг зөөвөрлөх хадгалах арга -MNS (ISO) 5667:2001. Усны чанар-дээж авах 3-р бүлэг.Гүний уснаас дээж авах
Нийт зардал						337,000

5.10. Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

“Цээцээ импекс” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт № 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Удирдлага зохион байгуулалтын зорилт	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Уурхайн удирдлагын авч	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Ажилчид		Үйл ажиллагааны зардлаар	Жилд 1 удаа

2	хэрэгжүүлэх арга	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын аюулгүйн хувцас хэрэгслээр хангах	Ажилчид		ХАБЭА-ын зардлаар	Жилд 1 удаа
3	хэмжээнүүд	Ажиллагсдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	Ажилчид		ХАБЭА-ын зардлаар	Жилд 1 удаа
4		БОМТ-ний биелэлтийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь өгч байх	Уурхайн удирдлага	-	-	Жил бүр
5		Жил бүрийн БОМТ-г БОАЖЯ-аар хянуулан баталгаажуулах	Уурхайн удирдлага	-	-	Жил бүр
Нийт зардал					-	

5.11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

Хүснэгт № 11. БОМТ-ийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	Дүүргийн засаг даргын тамгын газар, БОАЖЯ	Тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-нд өгөх санал, зөвлөмж	Жил бүрийн 11 сарын 30-нээс өмнө	Дотоод төлөвлөлтөөр	Цээцээ импекс ХХК-ний удирдлага	НБОГ, БОАЖЯ
2	БОАЖЯ	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	Уулын ажлын төлөвлөгөө батлагдсаны дараа	Дотоод төлөвлөлтөөр	Цээцээ импекс ХХК-ний удирдлага	БОАЖЯ

5.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зарсан зардал

Хүснэгт № 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тухайн жилийн БОМТБ-ийн нийт зардал, төгрөг 2023 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,100,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5,000,000
7	Осол эрсэдлийн менежментийн төлөвлөгөө	650,000
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	268,000
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	337,000
Нийт		7,325,000

“Цээцээ Импекс” ХХК-ний “Их булаг”-ийн барилгын чулууны ордыг уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2023 онд 7.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

ДҮГНЭЛТ

“Цээцээ импекс” ХХК-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараах дүгнэлтэнд хүрлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 7.3 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд нийт зардлын 50%–ийг нь БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. Журам шинэчлэн батлах тухай Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын А-36 тоот тушаал, 2011 оны 2 дугаар сарын 16, 1-р хавсралт
6. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
8. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших MV-007134 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Их булгийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2020 он
9. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших “Их булгийн барилгын чулууны орд”-ыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан, 2020 он
10. <http://www.legalinfo.mn//>

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

1. Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн хэсэг

Регистрийн дугаар	2	8	0	4	8	1	6
Аж ахуйн нэгж байгууллагын нэр	"Цээцээ Импекс" ХХК						
Байршил	Нэр					Код	
Аймаг, нийслэл	Улаанбаатар						
Сум, дүүрэг	Баянзүрх						

2. Ерөнхий мэдээлэл

Тусгай зөвшөөрлийн дугаар	М	V	0	0	7	1	3	4
Тусгай зөвшөөрлийн талбай, га	125							
Ашигласан эхэлсэн он, сар, өдөр	2	0	1	3				
Ашигт малтмалын төрөл	Дайрга							
Ашиглалтын төрөл	Дайрга							

3. Уул уурхайн ашиглалт

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайланд онд /ашиглалт хийсэн/
А	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	-	х	х
Ашигласан талбай	2	га	44.5	44.5
	3	мян.м ³	297.438	297.438
Хаягдал чулуулгийн овоолго	4	га	17.3	17.3
	5	мян.м ³	87470	87470
Хөрсний овоолго	6	га	17.3	17.3
	7	мян.м ³	57200.0	57200.0
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	8	га	0.06	0.06
Бусад	9	га	-	-

4. Уул уурхайн нөхөн сэргээлт

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Техникийн	Биологийн
А	Б	В	1	2	3
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га	56.22	56.22	56.22
	11	мян.м ³	-	-	-
Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	га	Мод тарих ажил тусгагдсан		
	13	мян.м ³	-	-	-
	14	га	Мод тарих ажил тусгагдсан		

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 09 сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай	15	мян.м ³	-	-	-
Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	га	Мод тарих ажил тусгагдсан		
	17	мян.м ³	-	-	-
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал	18	мян.төг	-	-	-
Тайлант онд нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан зардал	19	мян.төг	-	-	-
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө	20	мян.төг	-	-	-
Тайланд онд байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	21	мян.төг	-	-	-
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал	22	мян.төг	-	-	-
Тайланд онд байгаль хамгаалахад зарцуулсан зардал	23	мян.төг	-	-	-

ТАМГА

Захирал /Эзэн...../

/

Нягтлан бодогч...../

/

2022 оны 12-р сарын 30-ны өдөр